



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 23

Номгон

Тунгалаг санхүү аймгийн  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн VIII хуралдааны 8/02 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор аймгийн Нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 90 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тунгалаг санхүү аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв, зохион байгуулах ажлыг аймгийн жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж батлуулан, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын  
19-ний өдрийн 23 дугаар тогтоолын хавсралт



## ТУНГАЛАГ САНХҮҮ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Ерөнхий үндэслэл

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, холбогдох заавар журам өөрчлөгдөн мөрдөгдөж байгаа боловч төсөвт болон аж ахуйн нэгж, байгууллагын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт шаардлагын хэмжээнд хүрэхгүй, санхүүгийн зөрчил дутагдал буурахгүй байна. Санхүү, бүртгэлийн ажилтан нь нягтлан бодох бүртгэлийн мэдлэг, ур чадвартай байхаас гадна санхүүгийн зөвлөгч, шинжээч, харилцааны өндөр ур чадвар эзэмшсэн байхыг шаардаж байна.

Монгол Улсад санхүүгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг 50 орчим их, дээд сургууль, коллежийн нийт төгсөгчдийн 35-аас доошгүй хувийг зөвхөн нягтлан бодогч мэргэжлээр төгсдөг гэсэн судалгаа бий. Тэдгээрийн сургалтын хөтөлбөр, төгсөгчдөд тавих шаардлага янз бүр байгаа учраас практикт төгсөн гарч байгаа оюутнуудын мэргэжлийн ур чадвар, боловсролын түвшин эрс ялгаатай байдаг тул шинээр төгсөж ирж буй нягтлан бодогчдыг ажлын байранд нь дадлагажуулж, сургах шаардлага гарч ирдэг.

Сангийн яамны санхүүгийн тайлангийн “e-balance” програмын нэгтгэлд аж ахуйн нэгжүүдийн 2017 оны жилийн эцсийн тайлан гаргалт 81,3 хувьтай байна. Тайлангийн ирц харьцангуй өсөх хандлагатай байгаа хэдий ч зарим аж ахуйн нэгжүүд бие даасан нягтлан бодогч ажиллуулдаггүй, нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах мэдлэг дутмаг, удирдлага нь өөрөө санхүүгийн тайлан гаргаж байгаа нь санхүүгийн тайлан хүлээн авах, нэгтгэх ажилд хүндрэл учруулсаар байна.

Нөгөө талаар ихэнх аж ахуйн нэгжүүд нь жижиг учраас санхүүгийн тайлан гаргах бүртгэлийн стандарт нэвтрүүлэх ажил хэрэгжих боломж хязгаарлагдмал хэвээр байна. Нийт аж ахуйн нэгжийн 90 хувь нь орон тооны, мэргэжлийн нягтлан бодогчгүй, мэргэжлийн бус хүн санхүүгийн тайлан гаргаж байна. Аж ахуйн нэгж,

байгууллагууд татварын тайланг улирал бүр гаргадаг боловч санхүүгийн тайлангийн ирц хангалтгүй байна.

Төсөвт байгууллагуудын хувьд аймгийн Төрийн аудитын газраас Санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүнгээр 2016 онд 2,2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил гарч байсан бол 2017 онд 2,6 тэрбум төгрөг болж өссөн мөн 2016 онд “Хязгаарлалттай” дүгнэлт авсан төсвийн байгууллага 2 байсан бол 2017 онд 26 болж өссөн байна. Ихэнх зөрчил нь төсөв захирагч нар төсөв, санхүүгийн мэдлэг дутмаг, нягтлан бодогч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадвар хангалтгүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөөгүйгээс шалтгаалсан байна.

УИХ-аас 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан “Шилэн дансны тухай хууль” 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш 4 жил өнгөрөөд байна. Сангийн яамнаас Баянхонгор аймгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2016 онд 26 хувь гэж дүгнэж байсан бол 2017 онд 87 хувь болж тодорхой ахиц гарсан хэдий ч улсын хэмжээнд энэхүү үнэлгээгээр сүүлийн аймгуудын тоонд орж байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг иргэд, олон нийтэд мэдээлснээр төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн хэрэгжилтэд иргэдээс хяналт тавих нөхцөлийг бий болгох нь уг хуулийн үндсэн зорилт хэдий ч иргэдийн төсөв, санхүүгийн мэдлэг дутмаг байгаагаас мэдээлэл авах, төсөвт хяналт тавих байдал хангалтгүй хэвээр байна.

Орон нутгийн төсвийн орлого сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт, хуулийн өөрчлөлттэй холбогдуулан суурь нэмэгдэж байгаа боловч татвараас зайлсхийх байдал хэвээр байна. Энэ нь татварын байгууллага болон холбогдох байгууллагуудын мэдээллийн сан зөрүүтэй байгаа, орон нутагт шинээр төлбөр, хураамж авах боломж байгаа ч тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр гараагүй, эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой байна.

Дээрх нийтлэг алдаа дутагдлыг бууруулах, бүртгэлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, байгууллагын удирдлага, бүртгэл санхүүгийн ажилтны мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын оновчтой шийдвэр гаргалтын үндэс болсон нягтлан бодох бүртгэлийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

#### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтөлөлт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хэрэгжилтийг сайжруулж, төсөв захирагч, нягтлан бодогч, эд хариуцагчдын мэдлэг чадвар,

туршлагыг дээшлүүлэх, тэдгээрийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэн, зөрчил дутагдлыг бууруулах, хуулийн хэрэгжилтийг хангах аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд оршино.

ЗОРИЛТ 1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хэрэгжилтийг сайжруулах

ЗОРИЛТ 2. Орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх, төсвийн орлогын бүрдэлтийг сайжруулах

ЗОРИЛТ 3. Төрийн сангийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулж, эрсдэлийг бууруулах

ЗОРИЛТ 4. Санхүү, бүртгэлийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, удирдах ажилтнуудад санхүүгийн мэдлэг олгох

ЗОРИЛТ 5. Төсвийн ил тод байдлыг хангах, иргэд олон нийтэд төсөв, санхүүгийн анхан шатны мэдлэг олгох

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

-Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдөж ажиллана” гэж заасны дагуу шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх

-Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлөлт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хэрэгжилтийг сайжруулах

-Төсөвт байгууллагууд болон том аж ахуйн нэгжүүдийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдээллийн технологи, сүлжээ, программ хангамжийг бүрэн ашиглах нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллах

-Төсөвт байгууллагуудад программ ашиглалтын судалгаа гаргаж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн программыг бүрэн нэвтрүүлэх

-Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, баталгаажуулалтыг 85 хувьд хүргэх

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

-Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнд дүн шинжилгээ хийх

-Төрийн байгууллагын төсөв, санхүүгийн холбогдолтой баримт бичиг боловсруулалтыг сайжруулах

-Төсвийн төлөвлөлт, эдийн засгийн ангиллаар хууль, эрх зүйн эмхэтгэл боловсруулж, төсөв захирагч, нягтлан бодогч нарын хэрэглээ болгох

-Татварын Ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, татварын бааз суурийг нэмэгдүүлэх, дотоод нөөц бололцоог бүрэн дайчлах замаар орон нутгийн татварын орлогыг бодитой нэмэгдүүлэх

Гуравдугаар зорилтын хүрээнд:

-Төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг сайжруулах

-Сумдын Санхүүгийн албаны жишиг стандартыг бий болгох

-Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдлийг тодорхойлж, бууруулах арга хэмжээ авах

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

-Удирдах ажилтан, байгууллагын албан хаагчдад санхүүгийн мэдлэг олгох сургалт зохион байгуулах

-Төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүртгэл санхүүгийн ажилтнуудын мэдлэг чадвар, ёс зүйг дээшлүүлэх сургалт, семинарыг үе шаттайгаар зохион байгуулах

Тавдугаар зорилтын хүрээнд:

-Иргэд, олон нийт, ЕБС-ийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох олон талт үйл ажиллагаа зохион байгуулах

-Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах

-Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт,

санхүүжилт, хугацаа, хяналт шинжилгээ үнэлгээ

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, зохицуулах үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Статистикийн хэлтэс, Мэргэшсэн нягтлан бодогчдын Баянхонгор аймаг дахь салбар, төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн ажилтнууд, сумын хэмжээнд Сумын санхүүгийн алба, нягтлан бодогчид хариуцан гүйцэтгэнэ.

4.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах санхүүгийн эх үүсвэрийг ашиглана.

-Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө

-Бусад эх үүсвэр

4.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэст тайлагнана.

4.4 Хөтөлбөрийг 2018-2020 оныг дуустал хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

5.1. Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт сайжирна.

5.2. Улс, орон нутгийн төсвийн байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болж түүнийг мөрдлөг болгосноор “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн хэрэгжилт хангагдана.

5.3. Төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудын мэдлэг ур чадвар дээшилснээр мэдээ тайлангийн чанар сайжирч, санхүүгийн тайлангийн алдаа зөрчил буурч, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, санхүү, төсвийн хариуцлага дээшилнэ.

5.4. Аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт сайжирснаар татварын орлого нэмэгдэж, төсвийн орлого бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ.

5.5. Төсвийн байгууллагын хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнд үндэслэн төсвийн зарлагын хуваарилалтыг бодитой болгоно.

5.6. Төсвийн орлогын бааз суурийг бодитой нэмэгдүүлж, холбогдох байгууллагуудын татвар төлөгчийн мэдээллийн зөрүүг арилгана.

5.7. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт, мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулснаар улсын хэмжээнд жишиг төрийн сангийн нэгж, санхүүгийн алба бий болгоно.